

5 Нохойд хазуулахаас сэргийлэх алхам



Нохойд таны сайн нөхөр байж чадах ч заримдаа уурлсан, айсан үедээ хазгах, урдаг. Хазуулахаас сэргийлэх, аюулгүй, харууцлагатайгаар хамтдаа амьдрахыг судалцгаан.

1



Нэмэлт биеийг үйлүүлж, аймгаар (Би хоолоордо их харам суу. Уяагай уагай уурлахдаа амьдрах)

- Мөн амьтай адасч илгээгээр танихыг нь болгох
- Хавьд болон хүрээнд байхад нь, зайтай байгаарай.
- Өвчтэй болон урсгал байхад нь зайтай болгоорой.

2



Айсан болон уурлсан үед нь харахад их байгаарай.

- Би уурлсан үедээ эргэн харахгүйгээр
- Би айсан үедээ ууртал хөдлөх, зогсохгүй байгаарай.

3



Нэмэлт нөмрүүг ойлгож үед:

- Бэлтгэл хийгээрэй
- Мэд, уриа мэдэгдэхгүй эгсч.
- Харин таныг улам бол харуулахад биеийг харуулахгүй байгаарай.

4



Нэвдүү чөлөөгүй, хазуулан ойлгож байгаарай.

- Мөнх занзас эвчээрхэн үед байх үед хүлээгээрэй.
- Харин нэмэлт аюул бол харуулахад нь зайтай болго.

5



Хэрвэ нэмэлт хазуулах шалтгаан таны дээр өвчтэй үеэр сайр сайр угааж, эмчлэлт авартай ханд.

- Гэр бүлийнхэндээ хэлж, хэлж, ямар нэмэлт хазуулах шалтгаан, тэдгээр хөдлөх.

Бэлтгэл өөрөөр хэлж болон нэмэлт өвчлүүлж үзүүрээрэй. Өвчтэй нохой таних хэлснээр та өвчлөнө. Та нохойд харуулах дараа эмчлэлт авартай уурлах, эмчлэлт авартайгаар өөрийн амьсгал эвчээр. Өвчтэй амьтанд танихгүй болгоорой, танихгүй болгож, буу хэлж. Буу хэлж. Буу хэлж. Буу хэлж.

Бэлтгэл өөрөөр таних хэлснээр танд бүх нохойг жил бүр вакцин хазуулах хэрэгтэй гэрлийг өөрийн гэр бүл, багш, найз нөхөддөд хэлээрэй.

5 Нохойд хазуулахаас сэргийлэх алхам

Дэлхийн амьтан хамгаалах нийгэмлэгээс зөвлөгөө авч хийв.

Багш нарт зориулсан гарын авлага



Энэхүү гарын авлага нь сургалтын багц материалын нэг хэсэг бөгөөд нохойноос өөрийгөө хамгаалах талаар хэрхэн заах зааварчилгаа болно. Сургуулийн сурагчдад эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар мэдлэг олгоход дараах зурагт хуудас, гарын авлагыг ашиглах боломжтой. Мөн иймэрхүү хэлбэрээр байгаль орчин, амьтдын талаар мэдлэг олгож болох юм гэсэн санааг хүргүүлж байна.

Дэлхийн амьтан хамгаалах нийгэмлэг ба Галзуу өвчнийг хянах дэлхийн холбоо галзуу өвчинтэй тэмцэхэд хамтран ажиллах хүн бүрийг урьж байна. Хүний өвчлөлийн ихэнх хувь нохойд хазуулж, уруулснаас үүдэлтэй байдаг.

5 – 14 насны хүүхдүүд эрсдэлд ихээр өртөж байна. Нохойн вакцинжуулалт ба хазуулахаас сэргийлэх нь нохойн галзуу өвчнийг бууруулах шилдэг арга юм. Нохой бол хүний үнэнч нөхөр, хүнд хамгийн ойр байдаг тэжээмэл амьтан. Тэд бидний шилдэг найз, хамгаалагч, бас тэд бидэнтэй хамт байхыг тэмүүлдэг бол бид ч тэднийг гэр бүлийнхээ нэг гишүүнээр боддог.

Харилцаа

Гэхдээ ноход яагаад биднийг хаздаг юм бэ? Учир нь хүн, нохой хоёр харилцааны өөр өөр хэлээр ярьдагт оршино. Бид нохойн санааг ойлгодоггүй бөгөөд тэдэнтэй харьцахдаа ихэвчлэн өөрсдийгөө хазуулах нөхцөл байдалд хүргэдэг.

Хэрвээ бид нохойн зан төрхийг сайтар судалж чадвал энэ нөхцөл байдлаас зайлсхийх боломжтой юм. Ямар нэг шалтгаангүйгээр нохой биднийг хаздаггүй. Тэд айх, цочих, өвдөх зэрэг ямар нэг таагүй байдлаас үүдэн биднийг хаздаг. Мөн тэд эзэмшил газраа хамгаалах, хүн болон бусад амьтадтай нийгэмшиж дасаагүй зэргээс үүдэн ийм байдалд хүрдэг.

Галзуу өвчний эрсдлийг бууруулах

Хазуулахаас сэргийлснээр зөвхөн арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдахыг багасгахаас гадна галзуу өвчний эрсдлийг бууруулна.

Хүүхдүүд илүү өртөмхий байгаа учраас бид нохойтой зөв харьцах үндсэн таван алхмыг толилуулж байна

1 Намайг битгий үймүүлж, айлгаач. (Би хоолондоо их харам шүү. Уяатай үедээ уурлахдаа амархан.)

Мөн миний эд юмс ялангуяа гөлгийг минь бүү оролдоорой.
Хашаа болон үүрэндээ байхад минь зайтай байгаарай. Өвчтэй
болон унтаж байхад минь намайг бүү оролдоорой.

- Ямар нэг аюул заналхийлэлд хариу үзүүлэх нь нохдын үндсэн зан төрх юм.
- Тэд өөрийн эзэмшил нутаг, эзэн, гөлөгнүүд, хоол болон эд юмсыг үргэлж хамгаалж, харамлаж байдаг. Өөрт хамаарах эдгээр зүйлсийг алдах айдас, заналхийллийг байнга мэдэрч байдаг бөгөөд эдгээрийг хамгаалахын тулд бусдыг хазаж, урдаг.
- Нохдыг хүн болон бусад нохдоос тусгаарлагдмал байдалд байлгаснаар тэд ууртай, догшин, зожиг болдог. Ийм нохдод түрэмгий зан төрх илүү байдаг ба бусдыг хазаж, ураг магадлал ч өндөр байна.

- Эзний машин болон хашаагаа өөрийн эзэмшил нутаг гэж ноход тооцдог тул эдгээрт ойртох үедээ тун болгоомжтой байх хэрэгтэй.
- Нохдыг унтаж байхад болон өвчтэй үед биед нь хүрч, илж болохгүй. Тэд цочиж, хазах магадлал өндөр байдаг.
- Нохойн хажууд огцом хөдөлгөөн хийх, гэнэт чанга дуу чимээ гаргахгүй байхыг бид анхааруулж байна. Учир нь нохой эдгээр үйлдэлд хариу үйлдэл үзүүлдэг.



Эдгээр алхмуудыг хэрхэн заах вэ?


- Өөрийн зүйлсээ хамгаалах нохойн зан төрхийг хүүхдүүдийн өөрийн эд зүйлсээ хамгаалах үйлдлүүдтэй холбож үзүүлж болох юм. Хүүхдийн тоглоом юмуу, идэх зүйлийг өөрт нь хэлэлгүй нүдэн дээр нь авахад ямар хариу үйлдэл үзүүлэхийг бусдад нь харуулах гэх мэт.
- Уурласан нохой шүдээ ярзайлган архирч, сэрвээний үс нь босч, сүүл нь шулуун боссон байдалтай болдог.
- Айж эмээсэн нохой хойшоогоо ухарч, займчсан байдалтай болж, сүүлээ хавчин, чихээ хулмайлгаж, шүдээ бага зэрэг ярзайлгадаг.



2 Айсан болон уурласан үед минь надаас хол байгаарай.

Би уурласан үедээ шүдээ ярзайлгадаг. Би айсан үедээ сүүлээ хавчиж, зугтаахад бэлддэг.

- Нохой уурласан болон айсан байдлаа биеийн хэлээр үзүүлдэг ба эцсийн дүнд хазаж, урдаг. Хэрвээ хүүхдүүд эдгээр дохиоллыг мэддэг бол хазуулж, уруулахаас урьдчилан сэргийлж болох юм.



- Уурласан нохой шүдээ ярзайлган архирч, сэrvээний үс нь босч, сүүл нь шулуун боссон байдалтай болдог.
- Айж эмээсэн нохой хойшоогоо ухарч, займчсан байдалтай болж, сүүлээ хавчин, чихээ хулмайлгаж, шүдээ бага зэрэг ярзайлгадаг.



Эдгээр шинж тэмдгүүдийг хэрхэн заах вэ?

- Зурагт үзүүлбэрүүдийг хүүхдүүдэд үзүүлж тайлбарлаад дараа нь эргээд дээрх шинж тэмдгүүдийг асуух. Жишээ нь: Нохой өөрөө хэлж байгаа байдлаар: Миний сэrvээний үс боссон бол “Бүү надруу ойрт” гэж би хэлж байгаа шүү гэх мэт.
- Уурласан, айсан нохойн шинж тэмдэг үзүүлж буй биеийн хэсгүүдийг хүүхдүүдээр зуруулж, будуулах
- Том хүүхдүүдээр нохойн зан төрхүүдийг олон янзаар дүрслүүлж болно.



3 Намайг чамруу ойртох үед битгий хөдлөөрэй

- Мод шиг хөдөлгөөнгүй зогс.
- Хэрвээ газар унасан бол нуруугаараа бөхийж хөдөлгөөнгүй хэвтээрэй.

Ноход хөдөлгөөнтэй болон дуу чимээ гаргаж буй зүйлсийг элдэж хөөх зан төрхтэй байдаг. Хэрвээ чи гүйх юмуу хашгирах аваас ноход чамруу дайрах магадлал өндөр болдог. Харин хөдөлгөөнгүй, чимээгүй зогсвол чамайг сонирхох тэдний сонирхол буурч чамаас холдсоноор чи өөрийгөө сэргийлэх болно.

Мод шиг зогс.

Номхон зогсох хүүхдээр үүнийг үзүүлж болно. (Дуу чимээ гаргахгүй, нүдээ аньж, толгой үл ялиг тонгойж, гараа биедээ нааж хөдөлгөөнгүй зогсох)



Чулуу мэт хөдөлгөөнгүй байх

Энэ байрлал газарт унасан хүүхдэд тохирно. Энэ байрлалд царай болон гэдсээ хамгаалж, хөдөлгөөнгүй эвхрэн хэвтэнэ. Нохой сонирхохоо больж, явахад аажуухан, чимээгүй босч явах хэрэгтэй.



Хүүхдүүдэд эдгээр байрлалыг хэрхэн заах вэ?

- Хүүхдүүдээр дээрх байрлалуудыг зурагт үзүүлснээр хийлгүүлэх
- Мөн жүжигчилсэн байдлаар хийлгүүлж, эргэж асуух хэрэгтэй



4 Надруу чимээгүй, аажуухан ойртож байгаарай

Миний эзнээс зөвшөөрөл авч байж надад хүрээрэй. Хэрвээ намайг илэхээр бол нуруунаас минь эхэлнэ үү.

Ихэнх ноход хүн рүү дайрах гэж байгаа юм шиг санагддаг ч, тийм байдаггүй. Нохой тайван байхад хүмүүс дайрах нь гэж эндүүрч, элдэв хариу үйлдэл хийснээр нохойд уруулах тохиолдол цөөнгүй байдаг. Дараах чухал зүйлсийг хүүхдүүдэд заавал анхааруулаарай.

- Нохойд хүрэхээсээ өмнө заавал эзнээс нь зөвшөөрөл авах. Нохойтой орчинд насанд хүрсэн хүнтэй хамт байх. Нохойнд ойртохдоо аажуухан, тайван хөдөлж, өөрийн царайг нохойн толгойноос зайтай байлгах.
- Хэрэв нохой эргэж ирвэл түүнийг зогсоохыг хичээх хэрэггүй.



- Нохойнд хүрэхээр бол гараа хамар луу нь аажуухан ойртуулж, түүнд үнэртүүлж, тэр чамайг таньснаар нохойнд хүрч болно. Гараа түүнд ойртуулахдаа ямар нэг илүү хөдөлгөөн (ялангуяа хамар луу нь ойртуулж буй гар, хуруугаа хөдөлгөх) хийж болохгүй
- Нохойг илэхдээ эхлээд нуруу түүний хажуу хэсгээр илэх хэрэгтэй.

Нохойг хэрхэн илэх вэ?

- Өгөгдсөн зурагнуудыг таарах хэсэг бүрт ашиглахыг анхаарна уу.
- Дээрх үзэгдэл бүрийг хүүхдүүд (цэцэрлэгийн насны хүүхдүүдэд хүүхэлдэй ашиглаж болох юм)-ээр бодитойгоор хийлгэвэл илүү үр дүнд хүрэх болно.



5 Хэрвээ нохойд хазуулбал шархыг нэн даруй савантай усаар сайтар угааж, эмнэлэгт яаралтай ханд.

Гэр бүлийнхэндээ хаана, хэзээ, ямар нохойд хазуулснаа яаралтай, тодорхой хэлээрэй.

Хэрвээ нохой галзуу өвчний вакцин хийлгүүлээгүй бол өвчний халдвар авч, улмаар хүн хэзаж урснаар халдварлуулдаг. Үүнийг л хүүхдүүдэд маш сайн ойлгуулах хэрэгтэй.

- Нохойд хазуулсан болон нохойтой холбоотой бусад зүйлсийг гэр бүлийнхэндээ заавал хэлдэг байх



- Хазуулсан шархыг нэн даруй 15 минутын турш савантай усаар сайтар хөөсрүүлэн угаах
- Ойрхон байгаа эмнэлэгт яаралтай үзүүлж, эмчилгээ хийлгэх
- Хазсан нохойн талаар сайн асууж мэдээлэл авах хэрэгтэй. Үүнд: Хазсан нохойн өнгө зүс, хэмжээ, үүлдэр, хазсан газрын байрлалыг тогтоох. Мөн вакцинд хамрагдсан эсэх, эзний талаарх мэдээлэл байвал маш сайн
- Эдгээрээс гадна бусад санаж байгаа бүхнээ хэлэх хэрэгтэй. Сайн мэдээлэл авснаар галзуу өвчний эсрэг зөв арга хэмжээг авах болно.

Эрүүл мэндийн байгууллагууд уг нохойг хайж олоод, тодорхой хугацаанд ажиглаж, сэргийлэх арга хэмжээг авдаг.

Нохдыг хяналтад байлгаснаар үхлийн аюултай энэ өвчнөөс хүмүүний амьдралыг хамгаалдаг. Ноходтой зүй бусаар харьцах, алж хядах бус, тэднийг сайн ойлгож, зөв харьцсанаар бидний амьдрах орчин улам таатай болно.



Үйл ажиллагаа

- Дээр заасан сэдвүүдийн дагуу практик хичээлүүдийг заах (Цэцэрлэгийн хүүхдүүдэд хүүхэлдэй ашиглах)
- Галзуу өвчнөөс сэргийлэх мэдээллийг ахлах ангийн хүүхдүүдэд мэдээлэл (радио, телевиз, цахим хэлбэр)-ийн хэрэгслүүдийг ашиглан заах





Нохойг сайн мэддэг болсноор нохойноос үүсэх эрсдлүүдийг бууруулна. Үүний тулд тэдний биеийн хэлийг ойлгодог болох, өвдсөн үед нь эмчлэх, арчлах, хүндэтгэлтэйгээр харьцах гэх мэт.

Амьтдын хэрцгий байдал ихэвчлэн айдсаас үүдэлтэй байдаг. Тиймээс тэдэнтэй хүндэтгэлтэйгээр харьцаж, хүн, амьтан харилцан айдасгүй байх тийм орчныг бид бүрдүүлэх хэрэгтэй байна.

Тэжээмэл нохдыг дархлаажуулах нь галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга хэмжээ гэдгийг дахин хэлье. Тэжээмэл амьтадтай хариуцлагатай, зөв харьцах хандлагыг дэмжсэнээр галзуу өвчнийг таслан зогсоож чадна.



Дэлхий даяар галзуу болон галзуу төст өвчнүүдийн хүний өвчлөлийг таслан зогсоох, мал, амьтны өвчлөлийг бууруулах үйл ажиллагаа явуулдаг байгууллага

Website:
rabiesalliance.org



Дэлхийн амьтан хамгаалах нийгэмлэг

Website:
<https://www.worldanimalprotection.org/>



Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Website:
<http://who.int>



Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Website:
<http://nczd.gov.mn/>